



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын  
баримт бичиг батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.5.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9, 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Монгол Улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт болон бусад холбогдох хууль тогтоомж, заавар журмуудыг багцлан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн агентлагийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллахыг ерөнхий нягтлан бодогч Д. Дугармаа, тооцооны нягтлан бодогч М. Жанчивням, нярав Б. Мөнхцэцэг нарт үүрэг болгосугай.

3.Холбогдох хууль тогтоомж, заавар журамд өөрчлөлт орсон тухай бүрт “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг шинэчлэн батлуулж ажиллахыг ерөнхий нягтлан бодогч (Д.Дугармаа)-д даалгасугай.

ДЭД ДАРГА, ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.УРАНЗАЯА

142022 01035